



БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГА С.АЙГУЛ ТАНАА

МОНГОЛ УЛС
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-0251,
E-mail: comcor@iaac.mn, http://iaac.mn

2021.01.11 № 05/335
танай _____-ны № _____-г

Хувийн ашиг сонирхлын урьдчилсан
мэдүүлэг хянасан тухай

Баян-Өлгий аймгийн Нэгдсэн эмнэлгийн ерөнхий эмчийн албан тушаалд томилогдохоор нэр дэвшсэн Хавдырашийн Манчукийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6 дахь хэсэгт заасныг үндэслэн хянан үзэхэд ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал одоогоор тогтоогдоогүй болно.

Нэр дэвшигч нь тухайн албан үүргийг гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй нөхцөл байдалд дээрх хуулийн 8 дугаар зүйлд заасан мэдэгдэл, тайлбарыг тухай бүр гаргаж байх, мөн хуульд заасан хориглолт, хязгаарлалтыг хэрэгжүүлж ажиллах, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3, Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т заасан хугацаанд хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргахыг анхаарна уу.

Жич:Тус газрын Мөрдөн шалгах хэлтэст Х.Манчук нь мөрдөн байцаалтын 1813003640097 дугаартай хэрэгт шалгагдаж байна.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДҮН
ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА,
ЭРХЭЛСЭН КОМИССАР



Х.ХАШБААТАР



БЯАН-ӨЛГИЙ АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГА
С.АЙГУЛ ТАНАА

МОНГОЛ УЛС
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-0251,
E-mail: comcor@iaac.mn, http://iaac.mn

2021.02.10 № 05/1774
танай _____-ны № _____-т

Хувийн ашиг сонирхлын урьдчилсан
мэдүүлгийг хянасан тухай

Тус аймгийн нэгдсэн эмнэлгийн эмчилгээ эрхэлсэн орлогч даргаар томилогдохоор нэр дэвшсэн Асхабылын Данабекийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6 дахь хэсэгт заасныг үндэслэн хянан үзэхэд тухайн албан тушаалд томилоход ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал одоогоор тогтоогдоогүй болно.

Нэр дэвшигч нь тухайн албан үүргийг гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй нөхцөл байдагд дээрх хуулийн 8 дугаар зүйлд заасан мэдэгдэл, тайлбарыг тухай бүр гаргаж байх, мөн хуульд зүйлд заасан хориглолт, хязгаарлалтыг хэрэгжүүлж ажиллах нь зүйтэй.

Түүнчлэн нэр дэвшигч нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3, Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т заасан хугацаанд хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргахыг анхаарна уу.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДҮН
ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА,
ЭРХЭЛСЭН КОМИССАР



Х.ХАШБААТАР



БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГА
С.АЙГУЛ ТАНАА

МОНГОЛ УЛС
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-0251,
E-mail: comcor@jaac.mn, http://jaac.mn

20210402 № 05/3885
танай _____-ны № _____-т

Хувийн ашиг сонирхлын урьдчилсан
мэдүүлэг хянасан тухай

Баян-Өлгий аймгийн Нэгдсэн эмнэлгийн Чих, хамар, хоолой, нүд, эрүү нүүрний мэс заслын тасгийн эрхлэгчээр томилогдохоор нэр дэвшсэн Ойзерманы Ментай, Мэс заслын тасгийн эрхлэгчээр томилогдохоор нэр дэвшсэн Зейнэлханы Исагул нарын хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6 дахь хэсэгт заасныг үндэслэн хянахад тухайн албан тушаалд томилоход ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал одоогоор тогтоогдоогүй болно.

Нэр дэвшигч нар нь Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.3, Нийтийн албан нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3-т заасан хугацаанд хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг гаргаж, тухайн албан үүргийг гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй нөхцөл байдалд дээрх хуулийн 8 дугаар зүйлд заасан мэдэгдэл, тайлбарыг тухай бүр гаргаж байх, мөн хуульд заасан хориглолт, хязгаарлалтыг хэрэгжүүлж ажиллахад анхаарна уу.

Цаашид Монгол Улсын Их Хурлын 2016 оны 51 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг гаргах, хянах үйл ажиллагааг цахим хэлбэрт бүрэн шилжүүлсэн тул мэдүүлгийг тус газарт цахимаар ирүүлж байхыг үүгээр мэдэгдье.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДҮН
ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА,
ЭРХЭЛСЭН КОМИССАР *Х.ХАШБААТАР* Х.ХАШБААТАР

